

(ШҮҮМЖ)

С. Л. Тихвинский

ИСТОРИЯ КИТАЯ И СОВРЕМЕННОСТЬ**«Наука», М., 1976, 358 с.**

ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, дорно дахиныг судлагч нэрт эрдэмтэн С. Л. Тихвинскийн «Хятадын түүх, орчин үе» номыг 1976 онд Москвагийн «Наука» хэвлэлийн редакцияас 37,000 хувь хэвлэн нийтэлжээ. Энэхүү ихээхэн юм багтаасан мөртлөө харахад авсаархан нэгэн эмхтгэлийн талаар газар сайгүй бичигдсэн хэдий боловч ер хэд бичсэн ч илүүдэхгүй билээ. Учир нь 1-д уг эмхтгэлд хятадын түүхийн нэн эртний үеэс аваад нэн шинэхэн үеийг багтааж дотроос нь орчин үед үзэл суртлын хурц тэмцлийн бай болсон гол гогцоо асуудлуудыг сонгон авч марксист түүхийн шинжлэх ухааны байр сууринаас тайлбарласан, 2-рт, 60- 70-аад оны хятадын маоист түүх зохиолын марксизмын эсрэг, зөвлөлтийн эсрэг чиглэлийг илчлэн няцаажээ.

Иймд уг номыг хятадын үнэн түүхийн товч тольт буюу «Цагаан ном» гэлтэй бөгөөд тэрээр зөвхөн, түүх төдий биш түүхийг орчин үетэй холбож үзсэнд зохиогчийн гавьяа орших хийгээд ийм ч учраас уг ном нь цаг үеийн чухал хэрэгцээтэй чамбай зохиолоор барахгүй марксист нийгмийн шинжлэх ухаанд үнэт хувь нэмэр оруулсан шилдэг бүтээл юм. Чухам ийм утгаар уг номын талаар нэг биш нилээд шүүмж, сэтгэгдэл бичиж болох бөгөөд, ялангуяа номд түүхийн янз бүрийн үеийг хамарсан болохоор үе тус бүрээр буюу сэдэв сэдвээр нь тусгайлан бичиж болох юм. Бүтээлийн дотроос хятадын түүхийн эрт ба дундад зууны үетэй холбогдол бүхий 1, 2-р өгүүлэл, БНХАУ дахь их хятадын жанжлах үзэл ба түүхийн шинжлэх ухаан хэмээх сүүлчийн өгүүлэл юуны өмнө анхаарал татаж байна.

«Эртний ба дундад зууны үеийн хятадын олон улсын харилцааны түүхийн зарим асуудал» гэдэг өгүүлэлд зөвлөлтийн түүхчид, тухайлбал, Л. И. Думан, Л. С. Тихвинский нар хятадын төрт ёсны уламжлал үүсч хөрш зэргэлдээ ард түмэнтэйгээ харилцаа эхэлсэн үеийг МЭӨ II мянган жилийн 2-р хагас, 1 мянган жилийн 1-р хагаст гэж үзсэн байна. Онцлог нь бүр тэр үеэс эхлээд «тэнгэрээс заяасан тэгш бус эрх» гэгч шашны гаралтай хятад онол ёсоор «тэнгэрийн хүү» тэнгэрийн доорхийг бүгдийг захирах бөгөөд тэнгэрийн доорхид нь нэг талаас дэлхийн төв буюу «Дундад» улс, нөгөө талаас харь «бүдүүлэг» зах хязгаар буюу хятадаас бусад улс орон ард түмэн цөм багтах ёстой ажээ.¹ Иймээс А. А. Бокцанин, С. Л. Тихвинский нар Хятад буюу «Дундад» улс хятад бус бүх улс үндэстнийг захирах ёстой гэдэг энэ номнолын мөн чанарыг хятадын «Хилийн чанад дахь орны заасан албатын систем» («Система номинального Вассалитета зарубежных стран») гэдэг нэр томъёогоор жишээ болгои гаргажээ. (Зохиолын 15—16-р тал). Гэвч Хятадын гадаад бодлого эрт

¹ «Тянься» буюу «тэнгэрийн доорхид» 5 буюу 9 фу, фу тус бүрийн 500 ли газар нутаг багтана гэдэг ойлголтын талаар Л. И. Думаны өгүүлэлд тодорхой буй («Китай и соседи в древности и средневековые», М., 1970, 24—26-р тал).

дээр үеэс эхлэн дан ганц дээрх ерөнхий системийн хүрээнд алба барих, барьц өргөх, ураг болох зэрэг эвээр засах зарчим дээр үндэслэгдэж байсангүй нь мэдээж. Төвлөрсөн Цинь, Хан улс (МӨӨ III—МЭ Ш)-ын эхэн үед ч Манж Чин улс (XVII—XVIII зуун)-ын үед ч хэт түрэмгий гадаад бодлого явуулахад нь «хилийн чанад дахь орны заасан албатын систем) буюу манай түүхчдийн нэрлэсэн «тушмэг» систем ямар ч хаалт боомт болоогүйгээр барахгүй харин «албат»-аа «номготгох», «түвшитгэн тогтоох» зэрэг цэрэг улс төрийн элдэв томъёоллыг удаа дараа дэвшүүлэн хэрэглэхэд нь дархан халхавч болж зохиогчийн хэлснээр «эрх олгож» байснаас юун зайлах ажээ. Тийнхүү энэ «номготгох», «түвшитгэн тогтоох» харгис түрэмгий гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд хятадын арми гол үүрэг гүйцэтгэж, тухайлбал Манжийн үед Хятадад дагаар орохыг хүсээгүй Цахарын хаант улсыг 17-р зууны үед, Зүүнгарын Ойрадын хаант улсыг 18-р зууны үед тус тус цэрэг зэвсгийн хүчээр хүйс тэмтэрсэн билээ. Энэ түүхэн баримт бол «Хилийн чанад дахь орны заасан албатын систем»-ийн бүтцэд хүч хэрэглэх бодлого багтаж байдгийг илхэнээ харуулна. Энэ систем нь эцсийн эцэст «Хятад улс дэлхийг захирах» ёстой гэдэг Хятадын эрх баригч ангийн хуурамч үзэлд үйлчилдэг нь хятадын түүхийн анхны сурвалж бичиг Сыма Цингийн «түүхэн тэмдэглэл»-д хүртэл тусгагдсан байдаг. Хүннүтэй холбоо тогтоож, түүний баруун хөрш Усунь, Да-Юань, их бага Юэ чжи, Дася (Бактри), Ань Си (Парфи) зэрэг улс орныг судалж туршихаар томилогдон явсан түшмэл Чжан Цянь бичихдээ: Энэ мэт 5-6 улсыг аргаар эзэлбэл «газар нутгаа арван мянган ли гээр ахиулж, орд харшаа харь хэлтэнд гайхуулж, дөрвөн тэнгисийн хоорондох бүх нутагт сүр хүчээ мандуулж болно»¹ гэжээ. Чингэхлээр эртний ба дундад зууны үеийн хятадын улс хоорондын харилцааны онол. практик, арга хүчний харьцаа, түүний оньс хүрдийг тал бүрээс нь системчлэн судлах, тэгэхдээ түүхэн тодорхой цаг үед тухайн улс орон, ард түмэнтэй хэрхэн харилцаж байсан жишээний тодорхой илэрлүүд дээр авч үзэх (зохиолын 16-р тал) чиглэл дэвшүүлсэн нь орчин үеийн хятад судлалаар барахгүй, олон улсын харилцааны түүх судлалд онол практикийн чухал ач холбогдолтой санал юм. Чухам ийм буурь суурьтай судалгаанд тулгуурлан дэлхий дахинаа жанжлах үзэл, хятад бус ард түмэн (монгол, уйгур, казах, хотон, төвд зэрэг)-д хандах их гүрний дээрэнгүй үзэл зэрэг харгис бурангуй үзлүүд Хятадын эртний ба дундад зууны үеийн эзэн хаад, хөрөнгөтний бүгд найрамдах Хятад улсын эрх баригчдаар өв залгамжлагдан өнөөгийн Хятадын маоист эрх баригчдын гадаад бодлогын зэвсэг болон орсон тухай шинжлэх ухааны үндэстэй шударга дүгнэлт хийж чадах бөгөөд тийм дүгнэлтийг уг номд (31-р тал) хийсэн нь үнэхээр таашаалтай байна.

Эртний Цинь, Хан улсын үеэс эхлэн Хятадын гадаад бодлого онцгой түрэмгий шинжтэй болсон тухай зохиогчдын нотолгоо маш ойлгомжтой бөгөөд харин зохиогчийн иш татсан орчин үеийн хятадын томоохон түүхч Люй Чжэньюй ч бүр 1954 онд дахин хэвлэгдсэн «Хятадын үндэсний товч түүх» зохиолдоо Хан улс хүчирхэг болсон үедээ гадагш явуулж байсан дайн нь умардад Хүннү, өрнөдөд Си юй буюу «баруун хязгаар», дорнодод «Солонгос зэрэг таван зүгт явагдаж байсныг»² дурдсан боловч Хан улсын хаад тийнхүү харь улс орнууд тухайлбал «баруун хязгаарын» 30 улсыг дайн түрэмгийллийн замаар эзлэн авч «хятадын бүрэлдүүнд оруулсан»-ыг элдвээр цагаатгах «хятад зан»-гаас зайлж чадахгүй нь гайхалтай биш юм. Хятадын түүх бичлэгт эртнээс эдүгээ хүртэл зуршил болсон энэхүү «хятад зан»-тай холбогдуулан монгол түүхч Ванчин-

¹ Chapters from the Shihchi of Su ma Ch'ien. N-L. 1969. p. 280

²«Хятадын үндэстний товч түүх», Бээжин, 1954. (хятад хэл дээр) 278-р тал.

балын Инжиннаш (1837-1892) «Их Юан улсын мандсан төрийн хөх судар» гэдэг зохиолынхоо удиртгал хэсэг «товчит тольт»-д хэлбийх ташимгайг ялгасан шударга шүүмжлэл» хэмээх тусгай анги оруулан бичжээ. («Хөх судар» тэргүүн дэвтэр, 68р тал).

«Хэлбийх ташимгай» буюу түүхийг санааны зоргоор тааруулан завхаруулах явдлыг өнөөгийн хятадын түүхчид ч өвлөн авсныг монгол, зөвлөлтийн түүхчид марксист байр сууринаас илрүүлэн няцаасаар байгааг зохиогч тэдгээрийн бүтээлд тулгуурлан зүйтэй тэмдэглэжээ. (Зохиолын 44-45-р тал).

Түүхийг маогийнхны их хан үндэстний үндсэрхэх дээрэнгүй үзэлд захируулан тааруулах гэсэн хятадын өнөөгийн зарим түүхчдийн шигшүүрт оролдлогыг өрнө дорнын бусад олон эрдэмтэд уудлан илчилсээр байна. Жишээ нь, АНУ-ын Миннесотын их сургуулийн профессор Томас Т. Аллсен бичихдээ: 1960-аад оны эхэн хүртэл Монголын байлдан дагуулалтын түүхэн ролийн талаар Зөвлөлтийн түүхчидтэй үндсэндээ ижил дүгнэлттэй байсан хятадын түүхчид 1962 оноос эхлэн хувьсч тухайлбал, Монголын байлдан дагуулалтыг ерөнхийдөө дэвшилт үзэгдэл мэтээр «ревизионист» (зохиогчийн өөрийн нь хашилт-Э. П.) дүгнэлт хийсэн Хань Жулины «Чингис хааны тухай» гэдэг өгүүлэл гарч ирсэн юм. Харин зөвлөлтийн түүхчид Монголын эзэнт улсыг хүн төрөлхтний түүхэнд харгис, гоц хөнөөлт хүчин байсан гэж үзсэн хэвээр байна» гэжээ¹.

Чингис хааны ролийн талаар хятадын түүхчдээс өрнүүлсэн кампанийн үнэн зорилгыг БНМАУ, Дундад Азийн социалист бүгд найрамдах улсууд болон эрт урьд татар-монголын байлдан дагуулагч-феодалуудын эрхшээлд түр орсон бусад нутаг дэвсгэрийн санаархлаа «шинжлэх ухааны» иш үндэстэй болгох гэсэн оролдлого (зохиолын 52-р тал) гэж Л. С. Тихвинский нэгтгэн дүгнэжээ. 1976 онд Бээжинд хэвлэгдсэн «Цагаан хаант Орос улс Хятадыг түрэмгийлсэн товч түүх» (зохиогч нь Ши Да) гэдэг номд «манай улсын баруун хил уг нь Балхаш нуур байсан юм» гэж улигласаар байгаа нь С. Л. Тихвинскийн дээрх дүгнэлт хичнээн үнэн болохыг бэлхнээ харуулж байна.

Ер нь Хятадын эрх баригчдын жанжлах бодлогыг судлахдаа юуны өмнө Хятадаас хөрш зэргэлдээ орнуудынхаа талаар эртнээс нааш явуулж ирсэн бодлогын хувьсгалт өөрчлөлт, өвлөгдөгч байдлыг хамтад нь судалбал зохино. Эртний Цинь (МЭӨ III зуун) улсын үед Вьетнамыг хятад байлдан дагуулж эхлэжээ. Эхлээд цэрэг нь орж дараа нь нүүдлийн иргэд буюу цагаачин хятадууд цутгаж оржээ. Ийнхүү булаан дээрэмдсэн газар орныг колоничлох, хүн амыг нь хятадчлан уусгах «цаньши» буюу «хүр хорхой ялим модны навч идэх адил хөрш орнуудын нутгийг аажмиар эзлэх» бодлого нь хятад бус ард түмэн, ялангуяа Вьетнамын ард түмний хурц эсэргүүцэлтэй тулгарч байсныг зохиогч цохон тэмдэглэжээ.

Хятадын баруун умард хөрш Хүннү ч бүр Хан улсын У Ди хааны (МЭӨ 140—87) үеэс эхлэсэн Хүннүг эзлэх шунахай бодлогыг эсэргүүцэн тэмцсээр ирсэн бөгөөд гагцхүү «нэг бүдүүлгээр нөгөөгий нь даруулах» (ии чжи и) гэгч дипломат аргын тусламжтайгаар Хан улсын жанжин Бань Чао 85-р онд Хүннүгээс ширүүн цохилтыг өгч улмаар Сюаньди (МЭӨ 74—48) хааны үед Хүннүгээс хараат улсуудын удирдагчдыг өнгө мөнгөөр худалдан авах замаар хүннү нарыг ялжээ (номын 15-р тал). Гэвч Хүннү, Кидан зэрэг монголын эртний улсууд нь зарим үед зөвхөн ёс төдий түшмэг байдалтай явж ирсэн болохоос тэгш эрхтэй тусгаар байдлаа

¹Thomas T. Allsen. Mongol Rule in East Asia, Twelfth-Fourteenth Centuries: An Assessment of Recent Soviet Scholarship. "Mongolian Studies". Journal of the Mongolian Society, vol. 3. 1976. p. 7.

хэзээ ч алдаагүй тэр ч байтугай тэдгээрийн удирдагчид нь хятадын «тэнгэрийн хүү»-гийн дархан эрх ямбыг үгүйсгэж өөрсдийгөө нэгэн адил «тэнгэрээс заяат», «эзэн хаан» гэж өргөмжилж байсан нь¹ зохиогч номнодоо дурдсанаар (18-19 дэх тал) тэр үеийн Чосон (солонгос), Дайвьет (Вьетнам) улсууд Хятадаас зөвхөн нэр төдий хараат байсан боловч хэрэг дээрээ бүрэн биеэ даасан улсууд байсан гэдэг шударга дүгнэлттэй учир холбогдол нэгэн ижил болохыг нэмж удирдах нь зүйтэй юм.

Орчин үеийн хятадын маоист түүхчид даян дэлхийд жанжлах хятадын эртний хаадын их гүрний дээрэнгүй үзлийг өвлөн авч Энх Амгалан, Чингис хаан мэт цуст байлдан дагуулагчдыг агуу их баатар мэтээр магтан бичих болсныг зохиогч ХКН-ын удирдлагыг Мао Зэдүний жижиг хөрөнгөтний үндсэрхэх бүлэг булаан авсны шууд үр дагавар гэж дүгнэжээ (номын 31 дэх тал).

Үүнтэй холбогдуулаи дурдахад Хятадын суртал нэвтрүүлэг, хөрөнгөтний түүхчид дуу дуугаа авалцан Чингис хааныг олон янзаар бишрэн сайрхаж байгаа нь гайхалтай биш юм. Энд ялангуяа орчин үеийн хятадын маоист түүхчид онцгой үүрэг гүйцэтгэж байгааг шинэхэн баримт нотолж байна. «Гуанминь Жибао» сонин 1979 оны 9-р сарын 11-ний дугаартаа «Чингис хааныг үнэлэх тухай хэдэн асуудал» (зохиогч нь Цю Шушэнь) гэсэн томоохон өгүүлэл нийтэлжээ. Энэ өгүүлэлд Чингисийг өндөрт өргөмжлөхийн зэрэгцээгээр Чингис хаанаас өмнө Монгол нь Хятад улсын хаадын харьяанд захирагдаж байсан, монгол аймгуудын нутаглаж байсан нутаг нь Хятадын хаадад харьяалагдаж байсан нутаг гэж түүхийг шууд завхруулсан байна.

Өгүүлэн буй зохиолын «Ази, Европт хийсэн татар-монголчуудын байлдан дагуулалт» гэсэн өгүүлэлд Кан Ювэй мэтийн 19-р зууны сүүл үеийн шинэтгэгч үзэлтнүүдийн нийтлэл зохиолууд, Хятадын хувьсгалч- ардчилсан үзэлтэн Сүн Ятсен (1866-1925)-ны өгүүлэл, хэлсэн үгэнд харийн булаан эзлэгчдийг эрс эсэргүүцсэн шүүмжлэл элбэг байгаа бөгөөд хятадын агуу их зохиолч ардчилсан үзэлтэн Лу Синь Хятад дахь Монголын ноёрхол, Чингис хааныг биширсэн Гоминданы зандалчдыг хурцаар зэмлэсэн зэргийг иш баримтаар харуулжээ. Дээрх асуудлаар Фань Вэньлань, У Хань, Мэн Сымин, Ван Чуноу, Юй Юаньань, Шан Юэ гэх мэт нэрт түүхчид 60-аад оны эхэн хүртэл нэгдмэл үзэл санаа баримталж байсныг зохиогч тэдгээрийн бүтээлээс иш татан харуулаад харин 1961 оноос эхлэн БНХАУ-д их хан үндэстний дээрэнгүй үзлийн давалгааны дор Хятад дахь Монголын ноёрхолд хандах сөрөг хандлагыг эргэж үзэх шаардлагыг илэн далангүй дэвшүүлж тавиад Юан гүрний үе бол Хятадыг Монголчууд байлдан дагуулсны үрээр тогтсон Хятадын «агуу их нэгдэл»-ийн үе байсан, «Хятадын зах хязгаарт» ялангуяа Монголд «Хятадын тэргүүний соёл иргэншил»-ийн нөлөөгөөр эдийн засаг, соёл хөгжиж байсан мэтээр батлахыг оролдох болсныг зохиогч яруу тодоор задлан гаргажээ. Үүнийхээ зэрэгцээгээр хятадын зарим түүхчид, тухайлбал дээр дурдсан Хань Жулинь Монголчууд аян дайнаараа байлдан дагуулсан Газрын Дундат тэнгисийн эрэг хүртэлх бүх нутаг дэвсгэрийг Хятадын эзэнт улсын бүрэлдэхүүнд оруулсан ба БНХАУ-ын сургуулийн газрын зураг зохиогчид Хятадын хүчирхэг байх үеийн хил хязгаарт Дундад Азийг бүхэлд нь, Дорнод Европ, Ойрхи Дорнод, тэр ч байтугай Умард Африкийг оруулсныг (49-р тал) уг номд цохон тэмдэглэжээ.

¹ МЭӨ 176 онд Хүннүгийн Маодун шаньюй өөрийгөө «Тэнгэрээс томилсон их шаньюй»; Сүн улсын үед Киданы захирагч «Их Киданы эзэн хаан» (Да Цидань Хуанди) гэж нэрлэж байжээ. («Роль традиций в истории и культуре Китая». М., 1972, С. 206, 208.

Дашрамд дурдахад Нью Йоркт саяхан худалдагдаж байгаа Америк, Хятадын газрын зурагчдын хамтран үйлдсэн «Хятадын атлас»-т Хятад улсын түүхэн хил хязгаарыг Түркийг оролцуулан Газрын Дундад тэнгист хүртэл өргөтгөсөн тухай мэдээ нийтлэгджээ (Литературная газета», № 1, 1978). Энэ бол Хятадын өнөөгийн эрх баригчид газар дэвсгэрийн санаархлаа Хятадын ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд биш аль хэзээнээ олон улсын хэмжээнд дэвэргэн сурталдаж байгааг гэрчилж байна.

Манжийн төр нэг үндэстний доторхи болон үндэстнүүдийн хоорондохь зөрчлийг ашиглаж үндэстнүүдийг хооронд нь дайсагнуулах замаар ноёрхлоо тогтоож байсан тухай хятадын ахмад түүхчид Фань Вэньлань, Дун Цзимин, Шан Юэ нар тодорхой бичдэг байжээ. Тэд Чин улсын үед ч үндэстний дарлалын харгис ширүүн үе байсан гэж 1961 он хүртэл санал нэгтэй баталж байв. Тухайлбал, профессор Шан Юэ эрхэлж БНХАУ-д хэд хэдэн удаа хэвлэгдсэн «Хятадын түүхийн найрууллууд» номд Умард Хятадыг эзлэн аваад «манж нар ноёрхлоо гал мэсээр бэхжүүлж байв» гэжээ (Зохиолын 105-р тал). «Найруулал»-д манж нар нь Монгол, Уйгур, Төвдийг байлдан дагуулахдаа цус урсгасан харгис ширүүн дайн явуулж Чин улсыг «ард түмний шорон гяндан» болгосон нь Чин улсын байлдан дагуулалтууд нь шинж чанарын хувьд устган сөнөөгч, булаан дээрэмдэх дайн байсныг нотлон бичиж байлаа.

Гэтэл 1961 оноос эхлэн Лю Данянь мэт түүхчид Манжийн байлдан дагуулагчдын түүхийг цагаатган өргөмжилж эхэлсэн бол урьд нь баруун умард Хятад ба Синьцзяны түрэг омгийн ард түмэн XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн явуулсан Манжийн төрийн эсрэг ард түмний бослого хөдөлгөөнүүдийг Манжийн хаан Цянь Лун цус урсган дарж байсныг жигшин шүүмжилж байсан Люй Чжэньюй одоо тэдгээр байлдан дагуулагчдыг магтан сайшаадаг болжээ. Өнгөрсөн үеийн төрийн зүтгэлтнүүдийн түүхэн ролийг үнэлэх явдалд ийнхүү их хан үндэстний бодлогын үүднээс хандах болон Цзо Цзунтан мэтийн алан хядагчдыг хөөргөн мандуулах нь түүхийн бодит байдал ба ангич зарчимд харшлана гэж С. Л. Тихвинский зсхиолдоо дурдсан нь түүхийг завхруулах замаар тохируулах буюу их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй үзэлд захируулах гэсэн оролдлогыг илрүүлэн няцаасан зарчмын холбогдолтой чухал дүгнэлт юм.

Хятадын маоист түүхчдийн түүхийг гуйвуулж татар-монголын байлдан дагуулалтыг их хан үндэстний дээрэнгүй үзлийн үүднээс магтан сайшаах болсныг бүр 60-аад оноос эхлэн зөвлөлт, монголын түүхчид зарчимч ёсоор няцаасан бөгөөд ялангуяа 1971 онд хэвлэгдсэн «БНХАУ дахь түүхийн шинжлэх ухаан» эмхтгэл тухайн асуудалд нэгдсэн дүн шинжилгээ хийснээрээ чухал ач холбогдолтой болжээ. Маогийн түүхийг завхаруулагчдын хорт ажиллагааг зөвхөн социалист орны түүхчдээр барахгүй хөрөнгөтөн орны дэвшилт түүхчид л илрүүлэн шүүмжилж байгааг зохиогч АНУ-ын түүхч А. Фейерверкер, Д. Мак Фаркуар, Австралийн хятадыг судлагч эрдэмтэн Ч. Фиджеральд нарын бүтээлээр иш татан заасан байна.

60-аад оноос эхлэн Хятадад түүхийг эргэн шалгаж дахин хянах болсон явдлыг хятадад үндэстний үзэл газар авч зөвлөлтийн эсрэг үзлийг дэвэргэх болсон хийгээд улмаар эрин үед социализмын чиглэлээр өрнө зүгийн улс түмэн биш гагцхүү хятад улс «сонгодог» үлгэр жишээ болох ёстой мэтээр үзсэн «Шинэ хятад төвийн» хандлагатай холбоотой гэж тэдгээр эрдэмтэд үзэж байгаа ажээ.

Л. С. Тихвинскийн номынхоо «Их хан үндэстний жанжлах үзэл, БНХАУ дахь түүхийн шинжлэх ухаан» гэдэг өгүүлэлд Хятадад түү-

хийг гуйвуулах кампани өрнөж буй нь зөвлөлтийн эсрэг чиглэгдэж уг чанартаа Хятадын эрх баригчдын жанжлах бодлогод үйлчилж буйг хятадад «соёлын хувьсгал»-ын улмаас олон жилээр тасарч байгаад 1972 оноос эхлэн сэргээгдэж буй «Вэньу» («Эдийн соёл»), Каогу («Археологи») сэтгүүлүүдийн материал, мөн залуучуудыг их хан үндэстний дээрэнгүй үзлээр хүмүүжүүлэхэд зориулагдсан «Хятадын шинэ түүхийн түүвэр зохиол» гэдэг ерөнхий нэртэй 9 хэсэг товхимол (1973 онд хэвлэгджээ-Э. П.)-ын агуулга дээр үндэслэн илрүүлж Хятад дахь түүхийн шинжлэх ухаан нь тийнхүү бүхий л агуулга ба арга зүйгээрээ марксист түүхийн шинжлэх ухаанаас аль хэзээний зааглан хөндийрснийг цохон тэмдэглэжээ. (302-р тал)

1974 оноос хойш Цинь Шихуаш У Ди гэх мэт эртний хятадын эзэн хаадын эзлэн түрэмгийлэх, хавсарган нийлүүлэх гадаад бодлогыг мандуулах болсныг зохиогч «илт зөвлөлтийн эсрэг, монголын эсрэг чиглэлтэй, ЗСБНХУ, БНМАУ-ын эсрэг дайнд шууд уриалан дуудсан агуулгатайн гадна хөрш зэргэлдээ Солонгос, Вьетнам зэрэг орнуудыг дээр үед хятадын цэрэг түрэмгийлэн эзэлж удаан хугацаагаар эзэмшиж байсан учир тэдгээр орны эсрэг бас дайсагнаж байна» гэжээ (317-р тал). Чухам ийм зорилгоор хятадын маоист түүхчид умард хөрш Хүннүтэй байлдахыг эв журам эвдэнэ, хөрөнгө сүйтгэнэ гэж болгоомжилж байсан Күнзийн сургаалтнуудыг шүүмжлэх, Хятадыг «олон үндэстний нэгдмэл улс», иймд «Хүннүг түүхэн эрт үеэс нааш хятадын нэг ястан» («Жэньминь жибао», 1974. 11. 21) гэж нотлох болсныг Хятадын эрх баригчдын газар дэвсгэрийн өнгөлзлөгтэй холбон тайлбарлаж тийм оролдлого нь ямар ч шинжлэх ухааны үндэсгүй, зөвхөн түүхэн үнэнийг бүдүүлгээр завхруулж байгааг хэрэв маогийнхны далд үнэнийг (постулат) баримталбал өнөөгийн Италийн эрх баригчид эртний Римийн имперт харьяалагдаж байсан Англи, Франц, Бельги, ХБНГУ, Испани, Португали, Умард Африкийн тусгаар тогтносон улсууд, Ойрхи Дорнодын орнуудын нутагт санаархах эрхтэй болох ба хэрэв Дари, Македоны Александр, Чингис хаан, Их Могол, Осман, Габсбургийн эзэнт улсуудын хуучин хил хязгаарыг сэргээхийг шаардах буюу жишээлбэл Чингис хааны эзэнт улсын харьяанд байсан бүх олон үндэстэн ястныг цөмийг монголчууд гэж тооцвол түүхийн үзэлд огтхон ч эс тохирохыг зохиогч яруу тод харуулжээ. Тэрээр XVII зууны 30-аад оны үед оршин тогтнож байсан Зүүнгарын хаант улсыг XVIII зууны дундуур хүйс тэмтэрсэн манжийн түрэмгий түүхийг 1969 оны 10-р сарын 8-ны «БНХАУ-ын ГЯЯ-ны баримт бичиг» ёсоор хятадын дотоод асуудал болж байгаа Ши Юйсинь (ертөнцийг шинэчлэгч түүхч) гэгчийн өгүүллийг дээрх үндсэн дээр түүхийн баримтаар няцаажээ.

Чухам газар нутгийн түрэмгийлэл үйлдэх хэтийн зорилгоо биелүүлэхэд нь Бээжингийн неофашистуудад Монголын хаадыг өөрийн хаад, Ойрад, Монгол зэрэг үндэстэн ястнуудыг өөрийн үндэстэн ястан болгох шаардлагатай байгаа ажээ. Маоист болон хөрөнгөтний харгис түүхчдийн сурталчилж байгаа Чингис хааны тухай болон Монголын түүхийн тухай ном, өгүүллүүд нь шинжлэх ухааны эсрэг шинж чанартай болохыг

монголын болон зөвлөлтийн эрдэмтэд удаа дараа илчилсний дотор С. Л. Тихвинскийн «Хятадын түүх, орчин үе» ном хүндтэй байр эзлэх нь дамжиггүй.
Э. Пунцаг

¹ БНМАУ-ын түүх. 1 боть, УБ., 1967.

Б. Ширэндэв «Маогийн бүлгийн их гүрний дээрэнгүй үзэл»—«Намын амьдрал», 1968. № 14,

Ш. Нацагдорж. «Чингис хаан бол Монголын нэгдмэл улсыг үндэслэгч мөн» «Үнэн», 1962. 5. 31.

Н. Ишжамц. «Монголын нэгдмэл улс үүсч, Монголд феодализм бэхжсэн нь», УБ., 1974; «Маоизмын түүх-археологийн түрэмгийлэл»—«Проблемы Дальнего Востока» № 1, 1979.

Г. Сүхбаатар. «Хүннү-хятадын харилцаа ба маоизм»—«Маоизм, Маогийнхан», № 2, УБ, 1975.

Х. Пэрлээ, Г. Сүхбаатар. «Маогийнхан Монголын түүхийг гүйвүүлж байгаагийн үнэн учир»—«ШУА-ийн мэдээ», 1976, № 3.